


## Судалгааны тухай


### Тойм



#### Ил тод байдал:


**62** / 100

(Төсвийн нээлттэй байдлын индексийн оноо)



#### Олон нийтийн оролцоо:

**19** / 100



#### Төсвийн хяналт:

**80** / 100

Засгийн газрын төсвийн талаарх шийдвэрүүд тухайлбал, ямар татвар ногдуулах, төрийн ямар үйлчилгээ үзүүлэх, өрийн хэмжээ хэд байх зэрэг нь нийгэм дэх бүх хүнд чухал үр дагавартай. Засгийн газар эдгээр шийдвэр гаргалтад шаардагдах мэдээллийг олон нийтэд түгээж, тэдгээрийн зүгээс оролцох боломжийг хангах бодит сувгуудыг бүрдүүлснээр нийтийн мөнгийг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн зарцуулж буйг баталгаажуулах илүү боломжтой болно.

**Төсвийн нээлттэй байдлын судалгаа** нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгууруудыг ашигладаг хараат бус, харьцуулсан болон нотлох баримтад суурилсан дэлхийн цорын ганц судалгааны арга хэрэгсэл юм. Тухайлбал, засгийн газрын төсвийн мэдээллийг олон нийт авах боломж, улсын төсвийн үйл явцад олон нийтийн зүгээс оролцох албан ёсны боломжит сувгууд, мөн хууль тогтоох болон аудитын байгууллага зэрэг төсвийн хяналтын институциуд төсвийн үйл явцыг хянахад гүйцэтгэж буй үүргийг үнэлэх шалгууруудад тулгуурлан хийгддэг.

Уг судалгаа нь тухайн улсын иргэний нийгэмд өөрийн улсын засгийн газартай нийтийн хөрөнгийн ашиглалт болон энэ талаар өгч буй мэдээлэлд үнэлгээ өгч, зөвлөлдөхөд туслах зорилготой юм. Төсвийн нээлттэй байдлын судалгааны энэхүү 9 дэх хэвлэл нь дэлхийн 125 орныг хамарсан болно.


[www.internationalbudget.org/open-budget-survey](http://www.internationalbudget.org/open-budget-survey) цахим хуудаснаас судалгааны бүрэн аргачлал, 2023 оны дэлхийн тайлан, судалгаанд хамрагдсан улс орнуудын дүн, өгөгдлийн сан зэрэг илүү дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

## Төсвийн ил тод байдал


Төсвийн нээлттэй байдлын судалгааны энэ хэсэгт төв засгийн газар орлогоо хэрхэн бүрдүүлж, нийтийн хөрөнгийг хэрхэн зарцуулдаг талаар олон нийт мэдээлэл авах боломжийг хэмжинэ. Энэ хэсэгт төсвийн 8 үндсэн баримт бичгийн цахим хэлбэрээр, цаг хугацаандаа нийтлэгддэг, иж бүрэн эсэхийг 109 ижил жин бүхий үзүүлэлтээр хэмжиж, үлс бүрийг 0-ээс 100 хүртэлх оноогоор үнэлнэ. **Төсвийн ил тод байдлын 61 болон түүнээс дээш оноо нь тухайн улсын иргэд төсвийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнд мэдээлэлтэйгээр оролцоход хангалттай мэдээлэл нийтэлж буйг илтгэнэ.**

Монгол Улсын төсвийн ил тод байдлын оноо авбал зохих 100 онооноос **62** байна.

## Монгол Улсын төсвийн ил тод байдал бусад оронтой харьцуулахад:



# Монгол Улсын төсвийн ил тод байдал, 2012-2023 он



## Монгол Улсын төсвийн баримт бичгийн олон нийтэд нээлттэй байдал

ТЭМДЭГЛЭГЭЭ

- Олон нийтэд нээлттэй
- Хугацаа хэтэрч нийтэлдэг, эсвэл цахимаар нийтэлдэггүй, эсвэл зөвхөн дотоод хэрэгцээнд зориулан боловсруулдаг
- ⊘ Боловсруулдаггүй

Баримт бичиг	2012	2015	2017	2019	2021	2023
Төсвийн хүрээний мэдэгдэл	●	●	●	●	●	●
Засгийн газрын төсвийн төсөл	●	●	●	●	●	●
Батлагдсан төсөв	●	●	●	●	●	●
Иргэдийн төсөв	⊘	●	⊘	●	●	●
Явцын гүйцэтгэлийн тайлан	●	●	●	●	●	●
Хагас жилийн тайлан	●	⊘	●	⊘	⊘	●
Жилийн эцсийн тайлан	●	●	●	●	●	●
Аудитын тайлан	●	●	●	●	●	●

# Монгол Улсын олон нийтэд нээлттэй төсвийн баримт бичгийн агуулгын иж бүрэн байдал

## ТЭМДЭГЛЭГЭЭ

- **61-100 / 100:**  
Олон нийтэд нээлттэй
- **41-60 / 100:**  
Хязгаарлагдмал
- **1-40 / 100:**  
Сул

Төсвийн үндсэн баримт бичиг	Баримт бичгийн зорилго ба агуулга	Үнэлгээ хийсэн төсвийн жил	Баримт бичгийн агуулгын оноо
Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөл боловсруулахаас өмнө Засгийн газрын төсөв санхүүгийн бодлогын ерөнхий үзүүлэлтийг мэдээлнэ; Засгийн газрын эдийн засгийн талаарх төсөөлөл, хүлээгдэж буй орлого, зарлага, өрийн талаарх тоймыг гаргана.	2023	83
Засгийн газрын төсвийн төсөл	Засгийн газраас хууль тогтоох байгууллагад батлуулахаар өргөн барина; төсвийн орлогын эх үүсвэр, яамдад олгох төсвийн хуваарилалт, санал болгож буй бодлогын өөрчлөлтүүд болон тухайн улсын төсвийн байдлыг ойлгоход шаардлагатай бусад чухал мэдээллийг нарийвчилж өгнө.	2023	60
Батлагдсан төсөв	Хууль тогтоох байгууллагаас баталсан төсөв юм.	2023	33
Иргэдийн төсөв	Засгийн газрын төсвийн төсөл эсвэл батлагдсан төсвийн энгийн, хялбаршуулсан хувилбар, олон нийтэд төсвийн талаар чухал мэдээлэл хүргэх зорилготой.	2023	67
Явцын тайлан	Төсвийн төвлөрүүлсэн орлого, гарсан зарлага, хуримтлагдсан өрийн бодит гүйцэтгэлийн талаарх тодорхой цаг хугацааны давтамжтай гардаг мэдээллийг багтаана; улирал эсвэл сараар гаргана.	2022	89
Хагас жилийн тайлан	Төсвийн хэрэгжилтийн талаарх төсвийн жилийн хагасаар гаргах дэлгэрэнгүй мэдээлэл; төсөв боловсруулахад ашигласан эдийн засгийн урьдчилсан нөхцөлийг нягталж, төсвийн хүлээгдэж буй үр дүнгийн талаарх шинэчилсэн таамаглалыг багтаана.	2022	18
Жилийн эцсийн тайлан	Төсвийн жилийн эцэс дэх засгийн газрын данс, санхүүгийн байдлыг тайлбарлана, мөн төсвийн жилд тавьсан бодлогын зорилтын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшлийн талаарх үнэлгээг оруулбал нэн сайн.	2021	79
Аудитын тайлан	Аудитын дээд байгууллага гаргана. Энэ тайлан нь засгийн газрын жилийн эцсийн данс, санхүүгийн тайлан үнэн зөв бөгөөд иж бүрэн эсэхийг дүгнэнэ.	2021	62

Монгол Улсын 2023 оны төсвийн ил тод байдлын оноо **62** буюу 2021 оны үзүүлэлттэй ойролцоо байна.

## 2023 оны төсвийн нээлттэй байдалд орсон өөрчлөлтүүд

Монгол Улс төсвийн мэдээллийг дараах арга хэмжээ авснаар илүү нээлттэй болгосон:

- Хагас жилийн тайланг цахим хэлбэрээр нийтэлсэн.

### Зөвлөмж

Төсвийн ил тод байдлыг сайжруулахын тулд Монгол Улс дараах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:


- Төсвийн хагас жилийн тайланд макро эдийн засгийн гүйцэтгэл болон шинэчлэгдсэн таамаглалын харьцуулалт, эдийн засгийн болон хөтөлбөрийн ангиллаарх төсвийн зарлагын тооцоолол болон орлогын дэлгэрэнгүй мэдээллийг тусгаж мэдээллийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх.
- Баталсан төсөвт тухайн жилийн орлого болон зарлагын мэдээллийг эдийн засгийн иж бүрэн ангилал болон чиг үүргийн ангиллаар тооцон оруулах.

### Иргэдийн оролцоо

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь төсвийн үйл явцын үе шат бүрт олон нийтийн зүгээс жинхэнэ утгаар нь оролцох албан ёсны боломжуудыг санал болгодог эсэхийг үнэлдэг. Судалгаанд засгийн газар, хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллагын энэ чиглэлийн үйл ажиллагааг Төсвийн ил тод байдлын дэлхийн санаачилгын хүрээнд боловсруулсан Сангийн бодлогод олон нийтийн оролцоог хангах зарчмуудад ([Principles of Public Participation in Fiscal Policies](#)) нийцсэн 18 ижил жин бүхий үзүүлэлтээр шинжилж, улс орон бүрийг 0-ээс 100 хүртэл оноогоор үнэлдэг болно.


Монгол Улсын олон нийтийн оролцооны оноо авбал зохих 100 онооноос **19** байна.

## Монгол Улсын олон нийтийн оролцоо бусад оронтой харьцуулахад:



Олон нийтийн оролцооны шинэлэг арга барилын талаарх дэлхийн сайн туршлагын талаар <https://www.fiscaltransparency.net/case-studies/> цахим холбоосноос үзнэ үү.

## Төсвийн үйл явцад олон нийт оролцох боломж



## Зөвлөмж

Монгол Улсын Сангийн яам төсвийн хэрэгжилтийн үед иргэдээс цахимаар санал авах боломжийг бүрдүүлсэн боловч иргэдийн оролцоог цаашид улам бэхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай:

- Төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлж эхлэх.
- Эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг шүүд, эсвэл тэдгээрийг төлөөлдөг иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан төсвийн хэлэлцүүлэгт идэвхтэй татан оролцуулах.

Улсын Их Хурал улсын төсвийг батлахтай холбоотой иргэдээс санал авах боломжийг бүрдүүлсэн хэдий ч дараах арга хэмжээг чухалчлан хэрэгжүүлэх шаардлагатай:

- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх хэлэлцүүлгийн үеэр сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх.
- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч аудитын тайлан хэлэлцүүлгийн үеэр сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломж бүрдүүлэх

Үндэсний аудитын газар нь аудитын хөтөлбөр боловсруулахад иргэдийг оролцуулах механизмыг бий болгосон байна. Цаашид төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авах шаардлагатай:

- Холбогдох аудитад иргэд хувь нэмрээ оруулах албан ёсны механизмыг бий болгох.
- Аудитын хөтөлбөрөө тодорхойлохдоо иргэдийн саналыг хэрхэн ашигласан талаар олон нийтэд мэдээлэх.

## Төсвийн хяналт

Төсвийн нээлттэй байдлын судалгаа нь төсвийн үйл явцад хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллагын гүйцэтгэх үүрэг болон хяналт тавих байдалд дүн шинжилгээ хийдэг. Бүх улсыг 0-ээс 100 хүртэлх оноогоор дүгнэдэг бөгөөд оноог тооцохдоо 18 үзүүлэлтийг ижил жинтэйгээр авч үздэг. Үүний зэрэгцээ хараат бус төсвийн байгууллагын талаар нэмэлт мэдээллийг судалгаагаар цуглуулдаг болно (Шигтгээг харна уу).

Монгол Улсын хууль тогтоох байгууллага болон аудитын дээд байгууллага хамтран төсвийн үйл явцыг хангалттай түвшинд хянадаг бөгөөд төсвийн хяналтын нийлмэл оноо авбал зохих 100 онооноос **80** байна. Хоёр байгууллагын хяналтыг тус бүрээр нь доорх зурагт үзүүлэв.

## Хууль тогтоох байгууллагын хяналт



0 75 100

Хангалттай

## Аудитын хяналт



0 89 100

Хангалттай

ТЭМДЭГЛЭГЭЭ



0 - 40: Сул



41 - 60: Хязгаарлагдмал



61 - 100: Хангалттай

## Зөвлөмж

Улсын Их Хурал төсвийн төлөвлөлтийн үед хангалттай түвшний хяналт тавьдаг хэдий ч төсвийн гүйцэтгэлийн үе шат дахь хяналт хязгаарлагдмал байна. Хяналтыг цаашид сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг чухалчлан авч үзэх шаардлагатай:

- Хууль тогтоох байгууллагын байнгын хорооноос төсвийн гүйцэтгэлийн жилийн явцын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх.
- Төсвийн жилийн дундуур төсвийн хөрөнгийг захиргааны нэгжүүдийн хооронд шилжүүлэх тохиолдолд хууль тогтоох байгууллагатай зайлшгүй зөвшилцдөг байх.

### Төсвийн хараат бус байгууллагыг үүсгэн байгуулах шинэ хандлага

Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэмээх төсвийн хараат бус байгууллагатай. Зөвлөлийн хараат бус байдлыг хуулиар тогтоосон бөгөөд зөвлөл нь хууль тогтоох байгууллагад тайлагнадаг. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Засгийн газраас гаргасан албан ёсны макро эдийн засаг болон төсвийн төсөөллийн үнэлгээг хийж, нийтэлдэг.

*Төсвийн хараат бус байгууллагын үзүүлэлтийг Төсвийн нээлттэй байдлын судалгааны оноо тооцоход оруулаагүй болно.*

## Аргачлал

- 2023 оны Төсвийн нээлттэй байдлын судалгааг зөвхөн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал олон нийтэд зориулан нийтэлсэн баримт бичиг, болж өнгөрсөн үйл явдал, өрнөсөн үйл ажиллагаа болон гарсан өөрчлөлтүүдэд суурилан гаргав.
- Энэхүү судалгаа нь бүх улсын хувьд төсвийн хараат бус шинжээчдийн бөглөсөн асуулгад суурилдаг болно. Монгол Улсын хувьд уг судалгааны шинжээчид:  
Даваахүүгийн Оюунбадам, Члуунхүүгийн Нарантуяа  
Нээлттэй Нийгэм Форум, [oyunbadam@forum.mn](mailto:oyunbadam@forum.mn)
- Судалгааг улам чанаржуулах зорилгоор бүх улсын бөглөсөн асуулгын эхний хувийг нэрийг нь нууцалсан хараат бус шинжээч болон Монгол Улсын хувьд мөн Сангийн яамны төлөөлөгч нягталдаг.